МЭДЭЭ · 2023 оны 4-р сарын 14

ЭМГЭНЭЛ



ЭМГЭНЭЛ

БАЯНСАНГИЙН ДАГВАСҮНДЭЛ
/1962-2023/

Бидний хүндэт хүн, прокурорын ахмад ажилтан, Хууль цаазын шадар зөвлөх Баянсангийн Дагвасүндэл өвчний улмаас таалал төгсөж, хүнд гарз тохиолоо.

Б.Дагвасүндэл 1962 онд Өвөрхангай аймгийн Баян-Өндөр суманд төрж, Өвөрхангай аймгийн 10 жилийн сургуулийг 1980 онд, ОХУ-ын Эрхүү хотын Их Сургуулийг 1986 онд тус тус төгссөн.

Прокурорын байгууллагаас ажлын гараагаа эхэлж, 1986-1992 онд Дархан хотын прокурорын газрын орлогч прокурор, 1994-2000 онд Улсын ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2000-2005 онд Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх



ЭМГЭНЭЛ

БАЯНСАНГИЙН ДАГВАСҮНДЭЛ
/1962-2023/

Бидний хүндэт хүн, прокурорын ахмад ажилтан, Хууль цаазын шадар зөвлөх Баянсангийн Дагвасүндэл өвчний улмаас таалал төгсөж, хүнд гарз тохиолоо.

Б.Дагвасүндэл 1962 онд Өвөрхангай аймгийн Баян-Өндөр суманд төрж, Өвөрхангай аймгийн 10 жилийн сургуулийг 1980 онд, ОХУ-ын Эрхүү хотын Их Сургуулийг 1986 онд тус тус төгссөн.

Прокурорын байгууллагаас ажлын гараагаа эхэлж, 1986-1992 онд Дархан хотын прокурорын газрын орлогч прокурор, 1994-2000 онд Улсын ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2000-2005 онд Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, 2005-2010 онд Нийслэлийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга, 2010-2013 онд Улсын ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2013-2014 онд Сүхбаатар, Хан-Уул дүүргийн прокурорын газарт хяналтын прокурор, 2015-2017 онд Чингэлтэй дүүргийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга, 2017-2018 онд Улсын ерөнхий прокурорын газарт хяналтын прокурор, 2019 оноос Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн даргаар буюу прокурорын байгууллагад нийт 34 жил ажилласан байна. Мөн 1992-1994 онд Улсын Их Хурлын байнгын хорооны туслах байлаа.

Тэрээр чин шударга, хүнлэг энэрэнгүй зан чанартай, ахан дүүс, анд нөхөд, хамтран ажиллагсад, залуу үедээ туслан зөвлөгч, нөхөрсөг, гэр бүлдээ элбэрэл хайраар дүүрэн, ажил, мэргэжилдээ бахархалтай, нутаг усандаа нэр хүндтэй нэгэн байсан.

Б.Дагвасүндэлийн авьяас чадвар, хөдөлмөр бүтээлийг төр засгаас өндрөөр үнэлж “Алтан гадас одон”, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор тус тус шагнасан юм.

Таны минь хүнлэг сайхан сэтгэл, шударга хичээнгүй зан, өөдрөг хүсэл тэмүүлэл, ачлал хайр бүхэн бидний зүрх сэтгэлд мөнхөд хоногшин үлдэх болно.

Та минь эх нутгийнхаа тэнгэр дор эгнэгт мөнх нойрс доо.

Талийгаачийн гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд,
Прокурорын байгууллагын нийт хамт олон,
Ахмадын холбоо.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1821